

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны дугаар
сарын-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.4, 14.8.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд суурилсан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийн товлол болон зардлын төлбөрийн хэмжээ, түүнийг санхүүжүүлэх журам”-г хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Н.Эрдэнэбаяр/-д ДААЛГАХ нь:

2.1. Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд суурилсан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийг зохион байгуулах удирдамж, заавар болон үзлэгт хамруулах хуваарийг батлах;

2.2. Батлагдсан товлолын дагуу тусламж, үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн хүний нөөцийг бүрдүүлэх, чадавхжуулах сургалтыг зохион байгуулах;

2.3. Товлолд заасан тусламж, үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж болон үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлэх;

2.4. Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд суурилсан эрүүл мэндийн хяналт, тандалтын цахим бүртгэлийн сан бүрдүүлж, эрүүл мэндийн даатгалын цахим программ хангамжтай холбох;

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (Ц.Батбаатар)-т ДААЛГАХ нь:

3.1. Журмын дагуу анхан шатлалын эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлж буй тусламж, үйлчилгээг холбогдох эрх зүйн хүрээнд худалдан авах, нэхэмжлэлийг бодит цагийн горимоор хүлээн авч, чанарын болон төлбөрийн хяналтыг үндэслэн санхүүжилтийг олгох;

3.2. Эрүүл мэндийн даатгалын цахим программ хангамжид холбогдох нэмэлт өөрчлөлтийг оруулах;

3.3. Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд суурилсан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамрагдалт, анхан

шатлалын эрүүл мэндийн байгууллагад олгосон санхүүжилтийн хэмжээ, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлж, үр дүнг 2027 оны нэгдүгээр улиралд багтаан Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлд танилцуулах;

3.4. Холбогдох хууль, эрх зүйн актууд болон эрүүл мэндийн даатгалын сангийн 2027 оны батлагдсан төсөвтэй уялдуулан даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах, зардлын төлбөрийг нь санхүүжүүлэх харилцааг нэгдсэн, цогц байдлаар шийдвэрлэх тогтоолын төслийг боловсруулах, санал авч шинэчлэн батлуулах;

4. Тогтоолын дагуу хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд суурилсан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийг холбогдох тушаал, шийдвэрийн дагуу зохион байгуулах, цахим системд үзүүлсэн тусламж, үйлчилгээг бодит цагийн горимоор үнэн зөв бүртгэхийг даатгалын байгууллагатай гэрээ бүхий анхан шатлалын эрүүл мэндийн байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж ажиллахыг ажлын албаны дарга /Ц.Сарантуяа/-д даалгасугай.

ДАРГА

Э.БАТШУГАР

**Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд суурилсан эрүүл
мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийн товллол болон
зардлын төлбөрийн хэмжээ, түүнийг санхүүжүүлэх журам**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд суурилсан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийн товллол (цаашид “өвчин эмгэгийг илрүүлэх товллол” гэх)-ийг тодорхойлох, зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд суурилсан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг нь өвчин эмгэгийг илрүүлэх товллолын дагуу зорилтот насны хүүхдийг хамруулах үйл ажиллагааг зохион байгуулах харилцааг зохицуулсан төрийн захиргааны төв байгууллагын бодлого, шийдвэртэй нягт уялдана.

1.3. Энэ тогтоолоор батлагдсан товлосон хугацаанд хийгдэж буй урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг нь төлбөртэй үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамаарахгүй бөгөөд эрүүл мэндийн байгууллага нь уг тусламж, үйлчилгээг даатгуулагчаас аливаа төлбөр авахгүйгээр, харьяалал харгалзахгүй, чирэгдэлгүй үзүүлнэ.

Хоёр. Өвчин эмгэгийг илрүүлэх товллол

2.1. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд суурилсан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийг дараах товллолын дагуу хамруулна. Үүнд:

2.1.1. Цэцэрлэгт суурилсан эрт илрүүлэх үзлэг /дунд бүлэг/;

2.1.2. Сургуульд суурилсан эрт илрүүлэх үзлэг /1, 5, 9 дүгээр анги/;

**Гурав. 1.2. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд суурилсан эрүүл
мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийн зохион байгуулалт**

3.1. Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 301 дүгээр тогтоол болон түүнийг дагаж гарсан Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын хамтарсан тушаалын дагуу цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд суурилсан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг үзлэгийг зохион байгуулна;

3.2. Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээнд зөвхөн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж, үйлчилгээг хамааруулна.

3.3. Өвчин эмгэгийг илрүүлэх товллын дагуу үзүүлэх тусламж, үйлчилгээнээс Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт”-д заасан “Суурь тусламж, үйлчилгээ”-д хамаарах тусламж, үйлчилгээг “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-г баталсан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын “Нэг иргэнээр тооцсон төлбөрийн хэмжээ”-д хамааруулна.

**Дөрөв. Өвчин эмгэгийг илрүүлэх товллыг санхүүжүүлэх зардлын
төлбөрийн хэмжээ**

4.1. Өвчин эмгэгийг илрүүлэх товллын дагуу үзүүлэх тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх төлбөрийн хэмжээ:

№	Өвчин эмгэгийг илрүүлэх товллол	Үзлэгийн төрөл	Үзүүлэх тусламж, үйлчилгээ	Зардлын хэмжээ /төгрөгөөр/
1	Цэцэрлэгт суурилсан эрт илрүүлэх үзлэг	Дунд бүлэг	Биеийн ерөнхий үнэлгээ	-
			Хүүхдийн хөгжлийн үнэлгээ	-
			Амны хөндийн эмгэгийн илрүүлэг	-
			АУТИЗМ илрүүлэх	7,000.0
			Дүгнэлт, зөвлөмж	3,000.0
			Нийт	10,000.0
2	Сургуульд суурилсан эрт илрүүлэх үзлэг	1 дүгээр анги /6 настан/	Биеийн ерөнхий үнэлгээ	-
			Хүүхдийн хөгжлийн үнэлгээ	-
			Амны хөндийн эмгэгийн илрүүлэг	-
			Зүрхний цахилгаан бичлэг	10,000.0
			Дүгнэлт, зөвлөмж	3,000.0
			Нийт	13,000.0
		6 дугаар анги /11 настан/	Биеийн ерөнхий үнэлгээ	-
			Хүүхдийн хөгжлийн үнэлгээ	-
			Амны хөндийн эмгэгийн илрүүлэг	-
			Дүгнэлт, зөвлөмж	3,000.0
			Нийт	3,000.0
		9 дүгээр анги /15 настан/	Биеийн ерөнхий үнэлгээ	-
			Хүүхдийн хөгжлийн үнэлгээ	-
			Амны хөндийн эмгэгийн илрүүлэг	-
			Хот зуршил болон сэтгэцийн үнэлгээ	-
			Дүгнэлт, зөвлөмж	3,000.0
			Нийт	3,000.0

Тав. Цэцэрлэг, сургуульд суурилсан эрт илрүүлэх тусламж, үйлчилгээний нэгж тохиолдлыг тооцох, түүний зардлын бүрэлдэхүүн, төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх зохицуулалт

5.1. Эрүүл мэндийн даатгалын сангаас цэцэрлэг, сургуульд суурилсан эрт илрүүлэх тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх нэгж тохиолдлыг тооцох, хязгаарлах нөхцөл, түүний зардлын бүрэлдэхүүн

Тусламж үйлчилгээний төрөл	Нэгж тохиолдлыг тооцох	Нэгж тохиолдлыг хязгаарлах нөхцөл	Нэгж тохиолдлын зардлын бүрэлдэхүүн
1. Цэцэрлэгт суурилсан эрт илрүүлэх үзлэг			
Дунд бүлэгт суралцаж буй хүүхдэд хийх илрүүлэх үзлэг /36 сар/	Товлолт насны дагуу анхан шатны эрүүл мэндийн байгууллага цэцэрлэгт очих эсхүл эрүүл мэндийн байгууллагад ирж хамаарах тусламж, үйлчилгээнд бүрэн хамрагдсан тохиолдлыг нэгж тохиолдол гэж тооцно. Энэ тусламж, үйлчилгээнд доорх үзлэг багтана. 1. Асуумж авах, жин, өндөр (БЖИ), толгой, бүсэлхийн тойрог хэмжих 2. Хүүхдийн хөгжлийн асуумж авах, эмчийн үзлэг хийх, зөвлөгөө өгөх, Морбас үнэлгээ хийх 3. Амны хөндийн эмгэгийн илрүүлэг үзлэг хийх, зөвлөгөө өгөх 4. Аутизмын эрсдэлийг илрүүлэх асуумж 5. Эмчийн үзлэг болон эрсдэлийн үнэлгээ (ABCD), лавлагааны үнэлгээний үр дүн	-Энэхүү журмын 4 дүгээр хэсэгт заасан товлол болон тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх зардлын төлбөрийн хэмжээгээр хязгаарлагдана	Өвчин эмгэг илрүүлэх товлолыг холбогдох тушаалаар батлагдсан маягтын дагуу хийх ерөнхий үзлэг, эрсдэлийн үнэлгээ болон дүгнэлт, зөвлөмж өгөх тусламж, үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд: 1.Өвчин эмгэгийг илрүүлэх товлолт хугацаанд хамруулах, зохион байгуулах үйл ажиллагааны зардал 2.Зорилтот насанд тохирсон холбогдох стандарт, тушаал, эмнэл зүйн удирдамж, зааврын дагуу хийгдэх үзлэг, холбогдох маягтаар батлагдсан эрсдэлийн үнэлгээ, биеийн жингийн индекс, аутизмын эрсдэлийг илрүүлэх үнэлгээ, эмчийн дүгнэлт, зөвлөгөө, шатлал хооронд мэдээлэх үйл ажиллагааны зардал 3. Аутизмын эрсдэлийн үнэлгээг хийх тусламж, үйлчилгээний зардал 4.Эдгээрт шаардагдах эмнэлгийн нэг удаагийн хэрэгслийн болон холбогдох бусад зардал хамаарна.

	Санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт:	-Зөвхөн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчийн үзлэгт хамрагдаж, албан ёсны программ хангамжид бүртгэж, баталгаажуулсан тохиолдолд санхүүжүүлнэ.		
2. Сургуульд суурилсан эрт илрүүлэх үзлэг				
2.1. Сургуулийн 1 дүгээр ангийн сурагчид хийх эрт илрүүлэх үзлэг /6 настан/	Товлолт насны дагуу анхан шатны эрүүл мэндийн байгууллага цэцэрлэгт очих эсхүл эрүүл мэндийн байгууллагад ирж хамаарах тусламж, үйлчилгээнд бүрэн хамрагдсан тохиолдлыг нэгж тохиолдол гэж тооцно. Энэ тусламж, үйлчилгээнд доорх үзлэг багтана. 1. Асуумж авах, жин, өндөр (БЖИ), толгой, бугалгын тойрог хэмжих, хараа, сонсгол үнэлэх 2. Хүүхдийн хөгжлийн асуумж авах, эмчийн үзлэг хийх, зөвлөгөө өгөх 3. Амны хөндийн эмгэгийн илрүүлэг үзлэг хийх, зөвлөгөө өгөх 4. Зүрхний цахилгаан бичлэг 5. Эмчийн үзлэг болон эрсдэлийн үнэлгээ (ABCD), лавлагааны үнэлгээний үр дүн	-Энэхүү журмын 4 дүгээр хэсэгт заасан товлол болон тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх зардлын төлбөрийн хэмжээгээр хязгаарлагдана	Өвчин эмгэг илрүүлэх товлолыг холбогдох тушаалаар батлагдсан маягтын дагуу хийх ерөнхий үзлэг, оношилгоо, эрсдэлийн үнэлгээ болон дүгнэлт, зөвлөмж өгөх тусламж, үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд: 1.Өвчин эмгэгийг илрүүлэх товлолт хугацаанд хамруулах, зохион байгуулах үйл ажиллагааны зардал 2.Зорилтот насанд тохирсон холбогдох стандарт, тушаал, эмнэл зүйн удирдамж, зааврын дагуу хийгдэх үзлэг, холбогдох маягтаар батлагдсан эрсдэлийн үнэлгээ, биеийн жингийн индекс, аутизмын эрсдэлийг илрүүлэх үнэлгээ, эмчийн дүгнэлт, зөвлөгөө, шатлал хооронд мэдээлэх үйл ажиллагааны зардал 3.Зүрхний цахилгаан бичлэг хийх, түүнийг тодорхойлсон мэргэжлийн эмчийн дүгнэлт гаргахад шаардлагатай тусламж, үйлчилгээний зардал 4.Эдгээрт шаардагдах эмнэлгийн нэг удаагийн хэрэгслийн болон холбогдох бусад зардал хамаарна.	
	Санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт:	-Зөвхөн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчийн үзлэгт хамрагдаж, албан ёсны программ хангамжид бүртгэж, баталгаажуулсан тохиолдолд санхүүжүүлнэ.		
2.2. Сургуулийн 6 дугаар ангийн сурагчид хийх эрт илрүүлэх үзлэг /11 настан/	Товлолт насны дагуу анхан шатны эрүүл мэндийн байгууллага цэцэрлэгт очих эсхүл эрүүл мэндийн байгууллагад ирж хамаарах тусламж, үйлчилгээнд бүрэн хамрагдсан тохиолдлыг нэгж тохиолдол гэж тооцно.	-Энэхүү журмын 4 дүгээр хэсэгт заасан товлол болон тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх зардлын	Өвчин эмгэг илрүүлэх товлолыг холбогдох тушаалаар батлагдсан маягтын дагуу хийх ерөнхий үзлэг, оношилгоо, эрсдэлийн үнэлгээ болон дүгнэлт, зөвлөмж өгөх тусламж, үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд:	

	Энэ тусламж, үйлчилгээнд доорх үзлэг багтана. 1. Асуумж авах, жин, өндөр (БЖИ) хэмжих 2. Хүүхдийн хөгжлийн асуумж авах, эмчийн үзлэг хийх, зөвлөгөө өгөх, хавтгай тавхайн үзлэг, сүрьеэгийн эрсдэлийн үнэлгээ 3. Амны хөндийн эмгэгийн илрүүлэг үзлэг хийх, зөвлөгөө өгөх 4. Эмчийн үзлэг болон дараагийн шатлалд илгээх эсэх шийдвэр		төлбөрийн хэмжээгээр хязгаарлагдана	1.Өвчин эмгэгийг илрүүлэх товлот хугацаанд хамруулах, зохион байгуулах үйл ажиллагааны зардал 2.Зорилтот насанд тохирсон холбогдох стандарт, тушаал, эмнэл зүйн удирдамж, зааврын дагуу хийгдэх үзлэг, холбогдох маягтаар батлагдсан эрсдэлийн үнэлгээ, биеийн жингийн индекс, аутизмын эрсдэлийг илрүүлэх үнэлгээ, эмчийн дүгнэлт, зөвлөгөө, шатлал хооронд мэдээлэх үйл ажиллагааны зардал 3.Эдгээрт шаардагдах эмнэлгийн нэг удаагийн хэрэгслийн болон холбогдох бусад зардал хамаарна.
	Санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт:	-Зөвхөн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчийн үзлэгт хамрагдаж, албан ёсны программ хангамжид бүртгэж, баталгаажуулсан тохиолдолд санхүүжүүлнэ.		
2.3. Сургуулийн 9 дүгээр ангийн сурагчид хийх эрт илрүүлэх үзлэг /15 настан/	Товлолт насны дагуу анхан шатны эрүүл мэндийн байгууллага цэцэрлэгт очих эсхүл эрүүл мэндийн байгууллагад ирж хамаарах тусламж, үйлчилгээнд бүрэн хамрагдсан тохиолдлыг нэгж тохиолдол гэж тооцно. Энэ тусламж, үйлчилгээнд доорх үзлэг багтана. 1. Асуумж авах, жин, өндөр (БЖИ), толгой, бүсэлхийн тойрог хэмжих 2. Хүүхдийн хөгжлийн асуумж авах, эмчийн үзлэг хийх, зөвлөгөө өгөх, сүрьеэгийн эрсдэлийн үнэлгээ 3. Амны хөндийн эмгэгийн илрүүлэг үзлэг хийх, зөвлөгөө өгөх 4. Хүүхдийн хорт зуршил болон сэтгэцийн асуудлыг үнэлэх асуумж		-Энэхүү журмын 4 дүгээр хэсэгт заасан товлот болон тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх зардлын төлбөрийн хэмжээгээр хязгаарлагдана	Өвчин эмгэг илрүүлэх товлотыг холбогдох тушаалаар батлагдсан маягтын дагуу хийх ерөнхий үзлэг, оношилгоо, эрсдэлийн үнэлгээ болон дүгнэлт, зөвлөмж өгөх тусламж, үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд: 1.Өвчин эмгэгийг илрүүлэх товлот хугацаанд хамруулах, зохион байгуулах үйл ажиллагааны зардал 2.Зорилтот насанд тохирсон холбогдох стандарт, тушаал, эмнэл зүйн удирдамж, зааврын дагуу хийгдэх үзлэг, холбогдох маягтаар батлагдсан эрсдэлийн үнэлгээ, биеийн жингийн индекс, аутизмын эрсдэлийг илрүүлэх үнэлгээ, эмчийн дүгнэлт, зөвлөгөө, шатлал хооронд мэдээлэх үйл ажиллагааны зардал

	5. Эмчийн үзлэг болон дараагийн шатлалд илгээх эсэх шийдвэр		3.Батлагдсан маягтын дагуу авах Хот зуршил болон сэтгэцийн үнэлгээний зардал 4.Эдгээрт шаардагдах эмнэлгийн нэг удаагийн хэрэгслийн болон холбогдох бусад зардал хамаарна.
	Санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт:	-Зөвхөн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчийн үзлэгт хамрагдаж, албан ёсны программ хангамжид бүртгэж, баталгаажуулсан тохиолдолд санхүүжүүлнэ.	

---oOo--